

ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ УРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, АНХААРАХ АСУУДАЛ IMPLEMENTATION AND IMPROVEMENT OF EDUCATIONAL PROGRAMS TO INFLUENCE VIOLENT BEHAVIOR

Г.Хулан, Г.Энхжин

*ДХИС-ийн Сургалт, судалгааны 403-р анги шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн албаны сургуулийн 532-р дамжааны сонсогч*

Товч утга: Хорих ял эдэлж буй хоригдол, баривчлагдсан этгээд, хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтан болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээд тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн хүчирхийлэл бүхий зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, практик хэрэглээнд тулгарч буй асуудлыг судлан дүгнэлт, санал дэвшүүлээ.

Түлхүүр үг: Хүчирхийлэл үйлдэх зан үйл, эрх зүйн зохицуулалт, баривчлах байр, хорих анги дахь албадан сургалт, гэр бүлийн хүчирхийлэл, сургалтын хөтөлбөр

Abstract: The current status of the implementation of the training program to influence violent behavior among prisoners, detainees, convicts serving sentences other than imprisonment, and persons subject to coercive measures, including perpetrators of domestic violence, and the issues faced in its practical implementation were examined, conclusions made, and suggestions made.

Key words: Violent behavior, legal regulation, forced education in detention centers and prisons, domestic violence, training programs

УДИРТГАЛ

Монгол Улс 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг анхлан баталснаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хуулийн хүрээнд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл бүрдсэн билээ. Тус хуулийг 2016 онд шинэчлэн баталсны үр дүнд гэр бүлийн хүчирхийллийн талаар цагдаагийн байгууллагад мэдээлэх явдал ихсэж, нэг цэгийн үйлчилгээ, хамгаалах байр, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө, нийгмийн ажлын үйлчилгээ зэрэг хуульд заасан

хоширогчид үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэрүүд шинээр үүсэж эхэлсэн бөгөөд хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, хүчирхийлэл бүхий зан үйлд нь нөлөөлөх хууль, эрх зүйн орчин бүрдэж, практикт тодорхой алхмууд хийгдэж эхэлсэн. Тухайлбал, гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сайн дурын болон албадан сургалтын талаарх зохицуулалтыг хуульчилж өгсөн. Энэ нь нэг талаараа иргэд хууль эрх зүйн талаар мэдлэгтэй болсонтой холбоотой гэж бид үзлээ.

Нөгөөтээгүүр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвд зохион байгуулагдаж буй зан үйлд нөлөөлөх сургалт нь зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн, сөрөг үйлдлээ засах, эерэг төлөвшилийг бий болгох, үүргээ биелүүлэх хэвшилтэй болгоход зориулагдсан 9 багц сургалтын жишиг хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, энэхүү багц хөтөлбөрийн нэг нь “Хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх” асуудал юм.

Энэхүү хөтөлбөрийг хорих анги, баривчлах байр, баривчлах төвд хэрэгжүүлж эхэлсэн нь Эрүүгийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэхэд шинэ алхам болсон.

Энэхүү хөтөлбөрийг хорих ял эдэлж буй хоригдол, баривчлагдсан этгээд, хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтан болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд ялгамжгүй байдлаар шүүхээс оногдуулсан цагийн дагуу хорих анги, баривчлах байранд хэрэгжүүлж байгаа нь оновчтой шийдэл мөн эсэх, практик хэрэглээнд үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхийг судлан дүгнэлт хийхийг зорилоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Гэрлэлтийн үр дүнд бий болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг⁷ гэр бүл гэж тодорхойлсон байдаг. Энгийнээр тайлбарлавал гэр бүл гэдэг нь үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүрэг бүхий эцэг, эх, үр хүүхэд, хамаатан садны харилцаа холбоо бүхий тогтолцоо (Г.Уранбат, 2021) юм.

⁷ “Гэр бүлийн гишүүн” гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садны хүнийг хэлнэ.

Үүнээс үзэхэд хүний амьдралын хамгийн анхдагч орчин нь гэр бүл байдаг бол энэхүү орчинд хүн айх айдасгүй, ямар нэгэн хүчирхийлэл, дарамт, шахалтаас ангид, эрх тэгш амьдрах эрхтэй бөгөөд гэр бүлийн орчинд хүний эрх ямар нэгэн хэлбэрээр зөрчигдөх ёсгүй.

Тэгвэл хүчирхийлэл гэдэг нь хэн нэгэн этгээд бусдын эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн үйлдэл, эс үйлдэхүйг (Ч.Байгалмаа, 2021, хууд. 13) хэлнэ. Тухайлбал, өөрийн хүч чадал, давуу талаа ашиглан эрх мэдэл, хяналтаа тогтоож, айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх замаар зориуд бий болгож буй бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн болон эдийн засгийн гэх мэт бүхий л хэлбэрээр дарамт шахалт учруулж буй үйлдэл, эс үйлдэхүй зэргийг хүчирхийлэл хэмээн тайлбарладаг. Хүчирхийлэл нь олон хэлбэрээр, янз бүрийн орчинд өөр өөр аргаар үйлдэгддэг. Үүний нэг түгээмэл үйлдэгддэг хэлбэр нь гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг хүчирхийлэл юм.


Гэр бүлийн хүчирхийлэл гэж ураг төрөл, сэтгэл зүй, санхүүгийн холбоотой хүний зүгээс гэр бүлийн бусад гишүүд, хамт амьдарч байгаа болон хамт амьдраагүй ч хамаарал бүхий бусад хүмүүст хяналтаа тогтоож, эрх мэдлийн тэнцвэргүй байдалд оруулж байгаа үйлдлийг хэлэх ба Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (2017) хуулийн 5.1.1-д гэр бүлийн харилцаа хамааралтай хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод нь халдахыг хэлэх бөгөөд энэ нь жендэрт суурилсан хүчирхийллийн түгээмэл үйлдэгдэж байгаа нэг төрөл ба хүний амьд явах, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй, хараат бус байх эрхэд халдсан хүний эрхийн ноцтой зөрчил (Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт, хууд. 40) юм.

Гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн болон хувь хүний ухамсар, хүмүүжил, үзэл хандлагатай шууд хамааралтай бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн зарим үйлдлийг нийгмийн аюултай үзэгдэл бус зөвхөн тухайн гэр бүлийн дотоод асуудал, гарцаагүй хэрэглэх арга мэтээр хүлээн авах явцуу ойлголт нийгэмд тодорхой хэмжээнд оршсоор байгаа (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2007) нь гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоо буурахгүй байгаатай холбоотой гэж үзэж болно.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн жилүүдэд дунджаар 2,000,000-3,000,000 сая орчим зөрчил үйлдэгдэн эрх бүхий байгууллагаас шийтгэгдэж байгаа хэдий ч жил ирэх тусам үйлдэгдэх зөрчлийн тоо буурахгүйгээр

барахгүй ихсэх хандлагатай байна (Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ, хууд. 3). Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл болон архидаан согтуурах, мансуурах бодистой холбоотой зөрчил нэмэгдэж байгаатай хамааралтай бөгөөд 2024 оны байдлаар гэр бүлийн хүчирхийллийн 84604 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 17.3%-иар өссөн үзүүлэлттэй, 10867 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онд үйлдэгдсэн гэмт хэргийн тоотой харьцуулахад 6.8%-иар өссөн байна.

Зураг 1. Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо 2021-2024 он.



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн өсөлт нь нэг талаараа эерэг үзэгдэл бөгөөд иргэдийн аливаа хүчирхийллийн талаар хууль, хяналтын байгууллагад мэдээлэх үүрэг нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж болно. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээдэд хуулийн хүрээнд хариуцлага тооцох, цаашлаад сөрөг зан үйлээ засах, эерэг харилцаа хандлага бий болгоход чиглэсэн сургалтад хамруулах боломжийг олгож байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Эрүүгийн хууль (2016), Зөрчлийн тухай (2016), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (2017), Хүүхэд хамгааллын тухай (2024), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай (2017) хуульд заасны дагуу шүүхээс албадан сургалтад хамруулахаар заасан гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх сургалтыг холбогдох хөтөлбөрийн дагуу зохион байгуулж байна.

Мөн 2017 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн найруулж, гэр бүлийн хүчирхийллийг иргэний эрх зүйн маргаан бус гэмт хэрэг, зөрчил хэмээн үзэж, тухайн этгээдийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулахаар хуульчилж өгсөн. Үүний дагуу гэр бүлийн

хүчирхийлэл үйлдсэн хоригдол, баривчлагдсан этгээд, албадлагын арга хэмжээ авагдсан хүнд “Хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх” сургалтыг явуулж байна. Энэхүү сургалтыг хорих ангид ял эдэлж буй хоригдол, баривчлагдсан этгээд, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хэрхэн зохион байгуулж байгаа талаар нарийвчлан авч үзье.

Хорих анги дахь хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг нь нийгмийн суурь үнэт зүйл болох хүний анхдагч орчинд үйлдэгддэг хүчирхийллийн ноцтой хэлбэр бөгөөд Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн энэ төрлийн зөрчлөөс ялгагдах гол шинж нь гэмт хэргийг "байнга" үйлдэх объектив шинж болон учирсан хохирол, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл, үр дагавар нь энэ төрлийн зөрчлөөс их байдаг. Гэмт хэргийн "байнга" гэх объектив шинж нь гэмт этгээдээс гэр бүлийн хамаарал бүхий хүний эсрэг хүчирхийллийн үйлдлийг тодорхой хугацааны завсарлагатайгаар гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн байх, тэдгээрийн алинд нь ч ял шийтгүүлээгүй байх, гэмт зан төлөв нь амьдралд хэвшин тогтсон дадал зуршил болсон байх, үйлдэл бүр бие даасан гэмт хэргийн шинжийг агуулсан байх (Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ гарын авлага, 2020, хууд. 82) зэрэг юм.

Дээрх шинжийг агуулсан хүчирхийллийг үйлдэгч этгээдийн зан үйлийг нь өөрчлөх шаардлагатай. Тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүний сөрөг зан үйлийг өөрчилж, гэр бүлийн харилцаанд эерэг хандлага, дадал төлөвшилтэй, хуулиа дээдэлдэг иргэн болоход чиглэсэн сургалтад хамруулах хэрэгтэй.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын зорилгын хүрээнд гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах нь хорих байгууллагын үйл ажиллагааны үндсэн гол зорилт (Р.Оюунбадам, 2015, хууд. 14) юм. Хорих анги нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн хүнийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд шүүхээс албадан сургалтад хамрагдахаар заасан болон сөрөг зан үйл бүхий хоригдолд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222 дугаар зүйлд заасны дагуу болон “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр,

журам⁸”, “Хорих ял эдлүүлэх үеийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийн хүрээнд хоригдлын үйлдсэн гэмт хэргийн нөхцөл, шалтгаан болон түүний хувийн байдал, нас, хүйс, боловсрол, мэргэжил, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ялгамжтай байдлаар сургалт, нөлөөллийн ажлын төлөвлөлт хийж, хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх сургалтыг танхим, цахим, ганцаарчилсан хэлбэртэйгээр зохион байгуулж байна.

Гэм буруутай этгээдийн зан үйлд нөлөөлж, дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулах нь урт хугацааны үр дүнтэй шийдэл болдог. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх сургалтыг үр дүнтэй зохион байгуулах нь эрх зүйн хариуцлагаас гадна хүмүүжлийн, нийгмийн, сэтгэл зүйн, боловсролын үр нөлөө бүхий арга хэмжээ болж чаддаг.

Монгол улсын хэмжээнд хорих анги, байгууллагад нийт 62 нийгмийн ажилтан, 32 сэтгэл зүйч ажиллаж байгаагаас мэргэжлийн нийгмийн ажилтан 13, мэргэжлийн бус нийгмийн ажилтан 49, мэргэжлийн сэтгэл зүйч 13, мэргэжлийн бус сэтгэл зүйч 19 албан хаагч ажиллаж байна.

Зураг 2. Хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн тоо /мэргэжлийн болон мэргэжлийн бус/

Нийгмийн ажилтан						Сэтгэл зүйч				
Нийгмийн	Эрх зүйч	Сэтгэл зүйч, сэтгэл судлаач	Багш	Эдийн засагч	сэтгүүлч	Сэтгэл зүйч, сэтгэл судлаач	Эрх зүйч	Нийгмийн ажилтан	Радио техник команд	Багш, орчуулагч
13	40	4	3	1	1	13	12	4	1	2
62						32				
93										

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг мэргэжлийн сургагч багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар орох нь тухайн сургалтын ажлын үр дүнг нэмэгдүүлдэг.

⁸ Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2017 оны 04 сарын 04-ний өдрийн А/73 дугаар тушаалаар батлагдсан.

Мөн хорих ангид явуулах сургалтын сэдэв буюу агуулгыг нэгдсэн жишиг гарын авлага, хөтөлбөр болгон боловсруулах хэрэгтэй. Учир нь хорих ангийн нийгмийн ажилтан болон сургагч багш нар сэдвийн хүрээн дэх асуудлыг өөр өөрийн харах өнцгөөр харж бэлддэг. Ингэснээр сургалтыг хэрэгжүүлэхэд болон хоригдлуудыг үнэлэх тал дээр учир дутагдалтай байдаг.


Баривчлах байранд явуулж буй хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт

Баривчлагдсан этгээдэд зан үйлд нөлөөлөх сургалт орох эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147.5, Зөрчлийн тухай хуульд заасан олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, хүүхдийн эрхийг зөрчих, бэлгийн дарамт учруулах, хулгайлах, хөрөнгө завших гэсэн зөрчил үйлдсэн хүнийг албадан сургалт хамруулахаар хуульчилсан. Мөн холбогдох “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”, “Баривчлах байрны дотоод журам”-ын хүрээнд зохион байгуулж байна.

ШШГБ-ын харьяа Баривчлах төв нь 2021 онд зан үйлд нөлөөлөх сургалтын 9 багц жишиг хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн. Гэсэн хэдий ч энэхүү сургалтын хөтөлбөр нь 7-30 хоног баривчлагдсан этгээдэд хэрэгжүүлэхэд хангалттай нөлөө үзүүлэхүйц биш байгаа юм. Тийм ч учраас баривчлах байранд дээрх хөтөлбөрийн дагуу сургалт ороход хэцүү байдаг тул өөр хөтөлбөрийн дагуу явуулдаг (Дэжид, 2025). /ярилцлагын хэсгээс/ Үүнээс дээрх хөтөлбөрийг баривчлагдсан этгээдийн зан үйлийг өөрчлөхөд хангалттай нөлөө үзүүлэхүйц хэмжээнд боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага практикт тулгарч байгааг харж болно.

Баривчлах байранд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих гэх мэт зөрчил үйлдэн шийтгэгдсэн хүмүүс ихэвчлэн байдаг бөгөөд тэдэнд гэр бүлийн сэтгэл зүйн боловсрол, өөрийн үнэлэмжээ дээшлүүлэх, архианаас хамаарсан зан үйлийн эмгэг, хүүхдийн сэтгэл зүй сэдэвт сургалтуудыг ордог бөгөөд давтан зөрчил үйлдэн орж ирсэн хүмүүст ч өмнө нь орсон сургалтаа дахин дахин давтсаар байгаад гаргадаг (Дэжид, 2025). /ярилцлагын хэсгээс/ Энэ нь зан үйлд нөлөөлөх сургалтын үр дүн муу, хөтөлбөрүүд нь хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, сургалтын хөтөлбөрүүд хоорондоо харилцан уялдаагүй байгаатай холбоотой.

Зураг 3. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх шаардлага байгаа эсэх



Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 3, 4 дүгээр дамжааны 50 сонсогчоос “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх шаардлагатай юу?” гэсэн асуултад 47 нь буюу 94% нь шинэчлэх буюу сайжруулах шаардлагатай гэж хариулсан нь энэхүү сургалтын агуулга хийгээд хөтөлбөр, журамд өөрчлөлт оруулах хэрэгцээ байгааг илэрхийлж байна.

Хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг баривчлагдсан этгээдэд хэрэгжүүлэхгүй байгаа учир шинээр хөтөлбөр боловсруулах, эсхүл одоо ашиглаж байгаа сургалтын агуулга, хөтөлбөр дээр баяжуулалт хийн сайжруулах хэрэгтэй. Ингэснээр хүчирхийлэл үйлдэх зан үйл бүхий баривчлагдсан этгээдийн давтан зөрчил үйлдэх магадлал буурах боломжтой гэж үзэж байна.

Шүүхээс Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу 7-оос 30 хоног баривчлах шийтгэл оногдуулахад 10-50 цагийн сургалтад суухыг даалгадаг. Гэсэн хэдий ч “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”-т нэг хүний зан үйлд нөлөөлөх сургалтын цаг 23-56 цаг үргэлжлэхээр заасан байгаа нь тус хуулийн заалттай зөрчилдөж байна. Жишээлбэл, нэг удаагийн сургалтад дунджаар 6 хүн 2 цагийн хугацаанд хамрагдана гэж үзвэл 7 хоногт 2 удаа сургалт явуулах боломжтой ба энэ тохиолдолд 7 хоногийн баривчлах шийтгэвэртэй хүн 2-оос 4 цаг, 30 хоногийн баривчлах шийтгэвэртэй хүн 16 цагийн сургалтад хамрагдах боломжтой (Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт, мониторингийн тайлан, 2020, хууд. 4) байгаа нь ХЗДХ-ийн сайдын

тушаалаар баталсан хөтөлбөрт тусгагдсан цагтай тохирохгүй байгаа юм. Иймд дээрх сургалтын цагийг нэг мөр болгох хэрэгтэй.

Шүүхийн практикаас харахад 7 хоногийн баривчилгаанд 10 цаг, 14 хоногийн баривчилгаанд 10 цаг, 21-30 хоногийн баривчилгаанд 15 цагийн сургалтад тус тус суухыг (Б.Хишигсайхан, 2020) даалгаж байна. Гэтэл энэ нь тухайн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд эерэг хандлага төлөвшүүлэх, нөлөөлөхөд хангалттай хугацаа биш бөгөөд үр дүн үзүүлэх боломжгүй байгааг (Дэжид, 2025) эргэн харж, шинэчлэх шаардлагатай байна. Мөн шинээр сургалт эхлэх бүрд баривчлагдсан этгээдүүд солигддог учраас сургалтын үнэлгээ хийхэд төвөгтэй, шинэ мэдлэг олгох ажил дахин давтагддаг байдал нь үр нөлөө үзүүлэхүйц сургалт ороход хүндрэлтэй гэсэн дүгнэлт хийхэд хүргэлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5 дахь хэсэгт баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна гэж заасан. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэгчийг албадан сургалтад хамруулахын гол зорилго нь давтан зөрчил гаргуулахгүй байх юм. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалт нь гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх, амьдралын эерэг хандлагатай иргэн болгон төлөвшүүлэх зорилготой хэдий ч үр дүн нь зорилгоо бүрэн хангаж чадахгүй байна (Ц.Алтанцэцэг, 2020)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвөөс боловсруулан гаргасан 9 багц жишиг хөтөлбөрийг зөвхөн баривчлах шийтгэл эдэлж буй баривчлагдсан этгээдэд бус хоригдол, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд, хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтанд ямарваа нэгэн ялгамжгүйгээр адил хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ нь өөр хоорондоо ялгаатай гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ижил сургалт, эсвэл хэт олон хүнд явуулах нь сургалтыг үр дүнгүй болгодог. Тухайлбал, зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр, журамд үйлдсэн зөрчил, гэмт хэрэг тус бүрээр нь ялгамжтай байдлаар зохицуулалт хийж, шинэчлэлт хийх хэрэгтэй.

Учир нь хоригдол нь шүүхийн шийдвэрээр 1 жил ба түүнээс дээш хугацаагаар хорих ангид ял эдэлдэг бол, баривчлагдсан этгээд нь 7-оос 30 хоногийн хугацаагаар баривчлах байранд хоригддог. Өөр өөр хугацаа болон өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий ял шийтгэл эдэлж буй хүмүүст

адилхан зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь өөрөө сургалтын үр дүнг сайжруулах бус бууруулдаг. Нэн ялангуяа бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн Эрүүгийн хуулиар ял шийтгэгдсэн хоригдол, Зөрчлийн тухай хуулиар заасан зөрчил үйлдэн баривчлагдсан этгээдэд “Хүчирхийлэл бүхий зан үйлд нөлөөлөх” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь оновчтой бус шийдэл юм.

Сургалтын төрлүүдийг авч үзвэл хэрэг, зөрчил үйлдэгчдийн зан үйлд нөлөөлж, үйлдлийнх нь хор уршгийг ойлгуулж, дахин хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой өргөн хүрээний сургалтын агуулгатай журам боловсруулан гаргасан байна. Гэвч бодит нөхцөл байдал дээр албадан сургалтын үйл ажиллагаа бодит үр дүнтэй байх хийгээд сургалтын зорилгодоо ч бүрэн нийцэж чадахгүй байгаа нь энэ төрлийн зөрчил, гэмт хэргийн тоо буурахгүй байгаагийн томоохон нэг хүчин зүйл болж байна.

Зарим тохиолдолд ГБХ нь харилцан хоёр хүний буруутай үйлдэл, таагүй харилцаа, хохирогчийн буруугаас болж үйлдэгддэг тул энэ тохиолдолд сайн дурын сургалтад хэрэг, зөрчилд холбогдогч нарыг хамтад нь суулгадаг эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгтэй. ГБХТ хуульд заасан уг сайн дурын сургалтыг ямар тохиолдолд, хэнд, хэрхэн орох тухай зохицуулалт байхгүй, зөвхөн зөрчил үйлдэгчид баривчлах хугацаанд нь үр нөлөөгүй албадан сургалт ороод эргээд л нөгөө хүн нь хуучин нөхцөл байдал, гэр бүлийн таарамжгүй харилцаатай ахуйдаа очдог (Зөрчлийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл, хууд. 20). энэ байдлыг анхааран авч үзэх нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

Гэр бүлийн хүчирхийлэл бол зөвхөн хууль зөрчсөн үйлдэл биш, харин нийгмийн харилцааны гажуудал, зан үйлийн доголдолтой холбоотой үзэгдэл юм. Иймд гэм буруутай этгээдийг зөвхөн хуулийн хүрээнд хариуцлага хүлээлгэх бус сөрөг зан үйлийг нь өөрчлөхөд чиглэсэн албадан сургалт нь тогтвортой нийгэм, хүчирхийлэлгүй, аз жаргалтай, амар тайван гэр бүлийг бий болгох үр дүнтэй арга юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь зан үйлд нөлөөлөх сургалтыг хоригдол, баривчлагдсан этгээд, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд тус тус зохион байгуулахдаа дээрх этгээдүүдийн онцлог, шинж чанарыг харгалзан, шинжлэх ухаанд суурилсан хөтөлбөрийн дагуу, үр дүнтэй, хэрэгжүүлснээр хувь хүн болон нийт нийгмийн түвшинд эерэг өөрчлөлт авчрах боломжтой.

Практикт сургалтыг хэрэгжүүлэх нэгжүүд сургалтын цагийг шүүхээс оногдуулсан хугацаатай уялдуулахдаа агуулгын залгамж холбоог алдагдуулах, сургалтын хөтөлбөрт тусгагдсан агуулгыг хасах, хамааралгүй сэдэв оруулах, агуулгыг гүйцэт орохгүй байх зэрэг нөхцөл байдал үүсдэг.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн хоригдол, зөрчил үйлдэж баривчлагдсан этгээд, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд ялгамжтай байдлаар хүн бүрд чиглэсэн хөтөлбөр боловсруулан, урт хугацаанд, тасралтгүй явуулж байж эерэг үр дүн гарах боломжтой.

Шүүхээс Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу 7-оос 30 хоног баривчлах шийтгэл оногдуулахад 10-50 цагийн сургалтад суухыг даалгадаг. Гэсэн хэдий ч “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”-т нэг хүний зан үйлд нөлөөлөх сургалтын цаг 23-56 цаг үргэлжлэхээр заасан байгаа нь тус хуулийн заалттай зөрчилдөж байгааг нэг мөр болгох шаардлагатай бөгөөд зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг илүү боловсронгуй болгох хэрэгтэй.

САНАЛ:

Дээрх дүгнэлтээс үндэслээд хүчирхийлэл бүхий зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр өөрийн судалгаандаа үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/73 дугаар тушаалаар баталсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”-д заасан нэг хүний зан үйлд нөлөөлөх сургалтын цагийг хорих ангид ял эдэлж буй хоригдол, албадлагын арга хэмжээ авагдсан хүн болон баривчлагдсан этгээдэд ялгамжтай байдлаар тодорхой тусгаж өгөх

2. Зөрчлийн тухай хууль болон Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрт заагдсан зөрчилдөж буй хэсгийг нэг мөр болгох

Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйлийн 3-т заасан албадан сургалт нь 10-50 цагийн хугацаатай байна гэсэн заалт болон зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журамд сургалтын нийт үргэлжлэх хугацаа 23-56 цаг байна гэсэн заалттай зөрчилдөж байна. Үүнийг нэг мөр болгож шинэчлэх шаардлагатай байна.

Хоёр. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд

1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил үйлдэн ял эдэлж буй хоригдол, ялтан, баривчлагдсан этгээдэд явуулж буй хүчирхийлэл бүхий зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлэх.

Хүчирхийлэл үйлдсэн этгээдэд дээрх сургалтыг гэр бүлийн хүчирхийллээс үүдсэн нөхцөл байдлыг тусгайлан тохижуулж бэлтгэсэн зориулалтын танхимд явуулах нь гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг ойлгуулах боломжийг олгодог.

2. Тус сургалтын хөтөлбөрийг урт хугацаанд, тасралтгүй явуулах нөхцөл, боломжоор хангах

Гурав. Хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулах хүрээнд:

1. Хүчирхийлэл бүхий зан үйлд нөлөөлөх сургалт явуулах мэргэжлийн сургагч багшийг бэлтгэх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг чадавхжуулах

Сургалтын хэрэгжилт үр дүнд богино хугацааны дүн шинжилгээ хийж анхаарах асуудлыг тодруулж, шаардлагатай үйл ажиллагааг явуулж хэвшүүлэх;

Эх сурвалж

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ гарын авлага. (2020). УБ.

Б.Хишигсайхан. (2020). Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт /мониторингийн тайлан/. УБ.

Г.Уранбат. (2021). Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд анхаарах зарим асуудал. УБ.

Дэжид, Ш.-ы. х. (2025, 05 29). Хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийн талаар хийсэн ярилцлага. (Г. Г.Хулан, Interviewer)

(2020 он). Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд хийсэн шинжилгээ. УБ.

(2020). Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт, мониторингийн тайлан. УБ.

Зөрчлийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл. (2020). УБ.

Р.Оюунбадам, Т. (2015). Хорих байгууллага дахь нийгмийн ажил. УБ.

Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба салбар дундын зохицуулалт. (2019). УБ.

- Ц.Алтанцэцэг, С. (2020). Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт: Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал. Хууль дээдлэх ёс №1.
- Ч.Байгалмаа, Ш. (2021). Хүчирхийлэл үйлдэх зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр. УБ .
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2007). Retrieved from Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=202238>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2016). Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2016). Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12695>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2017). Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12393>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2017). Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12393>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2024). Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140463602711>